



МОНГОЛ УЛС, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
13-р хороолол, Олимпийн тудамж, Дугаар 39, G center, 3,4  
дэвхарт  
Утас:+976-75756000, Э-Шуудан: info@mig.mn

## “ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ”-ЫН ГЭРЭЭ

№ ИНЕГ/УЗ/52/2022  
№ 22201/1257

### БАТЛАВ:

Даатгуулагчийг төлөөлж:

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА

/СМОНХНАСАН/



Даатгагчийн төлөөлж:

МИГ ДААТГАЛ ХХК  
“МИГ ДААТГАЛ” ХХК-ИЙН  
БҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
УЛААНБААТАР ХОТ  
/С.АНУУЖИН/



**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨРӨЛЖСӨН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**

2022 оны 12-р сарын 21-ны өдөр

Дугаар 22201/1257

Улаанбаатар хот

**ДААТГАЛЫН ХЭЛБЭР:**

Тээврийн хэрэгслийн төрөлжсөн даатгал

**ДААТГУУЛАГЧ:**

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Агаарын тээврийн үйлчилгээ

**ХАЯГ, БАЙРШИЛ:**

МОНГОЛ УЛС, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 21  
дүгээр хороо, Буянт-Ухаа. Иргэний нисэхийн  
үндэсний төвийн байр  
Утас: 71283289  
И-Мэйл: sumiyajav.b@mcaa.gov.mn

**ДААТГАЛЫН ЗҮЙЛ:**

Агаарын хөлгийн газрын үйлчилгээ, аэродром  
талбайн засварын үйлчилгээ, гол унтраах, авран  
хамгаалах, шатахуун тээврийн болон нийтийн  
тээврийн автомашин, механизм, тусгай тоног  
төхөөрөмж, тухайн тээврийн хэрэгслийн нэмэлтээр  
тоноглосон тоноглолууд

**ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:**

2022 оны 12 сарын 21-ний өдрөөс  
2023 оны 12 сарын 20-ний өдрийн 24:00 цаг хүртэл  
хүчин төгөлдөр байна.

**ДААТГУУЛАГЧИЙН ӨӨРИЙН  
ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:**Тээврийн хэрэгслийн сонгосон багцаас хамаарч  
өөрийн хүлээх хариуцлага байхгүй**ДААТГАЛЫН НИЙТ ҮНЭЛГЭЭ:**

14,858,376,538₮

**ҮНДСЭН БОЛОН НЭМЭЛТ ЭРСДЭЛИЙН  
ХУРААМЖИЙН ХУВЬ:**

0,43%

**ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖ**63,891,019.11₮ /Хураамжийг 2 хувааж төлөхөөр  
тохиролцов/**ДААТГАЛЫН ХУРААМЖ ТӨЛӨХ  
ХУГАЦАА:**

- Гэрээнд 2 тал гарын үсэг зурж баталгаажуулсны  
дараа ажлын 3 өдрийн дотор 90% болох  
57,501,917.20 төгрөгийг;
- Гэрээний хугацаа дуусгавар болж, гэрээ дүгнэсэн  
акт үйлдсэний дараа үлдэгдэл 10% болох

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Даатгагчийг төлөөлж:

“МИГ ДААТГАЛ” ХХК-ийн  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

/Э.АРИУН ЭРДЭНЭ/

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

/Д.АМАР-АМГАЛАН/

Даатгуулагчийг төлөөлж:

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА

/Д.ХАТАНГААТАР/

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДҮРМИЙН  
БОЛОВСРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

/П.АРИУНВОЛД./

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА

/Д.ПУРЭВ ОЧИР/

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗАХИАЛАГЧИЙН  
АЛБАНЫ ДАРГА

/Б.АМАРТУВШИН/

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗАХИАЛАГЧИЙН  
АЛБАНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ТАСГИЙН ДАРГА

/Л.ГАНБАТ/

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭ****НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү даатгалын гэрээгээр (цаашид “Гэрээ” гэх) Даатгуулагч Гэрээнд заасан даатгалын зүйлээ Даатгагчид даатгуулж даатгалын хураамж төлөх, Даатгагч нь даатгалын тохиолдол учирсан үед гарсан хохирлыг Гэрээнд заасан нөхцөлийн дагуу нөхөн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Даатгагч, Даатгуулагч талууд (цаашид хамтад нь “Талууд” гэх) Гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү даатгалын үйлчлэх хүрээ нь Монгол улсын нутаг дэвсгэр байна.

**ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

- 2.1 Гэрээнд дурьдагдсан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 2.1.1 “даатгагч” гэж Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын вийл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан “МИГ Даатгал” ХХК-ийг;
  - 2.1.2 “даатгуулагч” гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд, тухайн байгууллагад хөдөлмөрийн гэрээтэй ажилтан болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын баталгаанд нэр нь бичигдсэн зөвшөөрөгдсөн жолоочийг;
  - 2.1.3 “даатгалын баталгаа” даатгалын зүйл, үнэлгээ, хугацааг тусгасан даатгалын гэрээ хийсэн тухайг нотолж даатгуулагчид олгосон баримт бичгийг;
  - 2.1.4 “даатгалын зүйл” гэдэгт Даатгуулагчийн өмчлөл, эзэмшилд буй тээврийн хэрэгслийг (гэрээний хавсралт нэг бүрчлэн тусгасан)-ийг;
  - 2.1.5 “даатгалын эрсдэл” гэж даатгалын зүйлд хохирол учруулж болох Гэрээнд заасан орчин, нөхцөлийг;
  - 2.1.6 “даатгалын тохиолдол” гэж даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бурдэхийг;
  - 2.1.7 “даатгалын хураамж” гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
  - 2.1.8 “даатгалын нөхөн төлбөр” гэж даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;
  - 2.1.9 “даатгалын үнэлгээ” гэж даатгалын зүйлийн даатгалд хамрагдсан мөнгөн илэрхийллийн хэмжээг;
  - 2.1.10 “Өөрийн хүлээх хариуцлага” гэж даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ буюу даатгуулагчийн хариуцах мөнгөн төлбөрийн хэмжээг;
  - 2.1.11 “Хүндэтгэн үзэх шалтгаан” гэж давагдашгүй хүчин зүйлс, хүнд нөхцөл байдал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамааран гэрээний эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнийг.
  - 2.1.12 “Нөхөн сэргээх үнэлгээ” гэж тээврийн хэрэгсэл нөхөн сэргээгдэх, засварлагдахад гарах шууд зардал буюу сэлбэгийн зах зээлийн дундаж үнэ мөн эд ангийг засах зардал, будаг туслах материалын зардал, ажлын хөлсний зах зээлийн дундаж үнийг;
  - 2.1.13 “Зах зээлийн бодит үнэ” тээврийн хэрэгслийг даатгах үед зах зээл дээрх тухайн тээврийн хэрэгсэлтэй үйлдвэрлэсэн он, марк, загварын хувьд адил тээврийн хэрэгслийн зах зээл дээрх үнэ;

- 2.1.14 “Элэгдэл” гэж тээврийн хэрэгсэл нь хэвийн ашиглалтын явцад зөвхөн хугацаанаас хамааран хорогдсон өргтгийг;
- 2.1.15 “Жолоо шилжүүлэх үеийн эрсдэл” гэж даатгалтай тээврийн хэрэгслийг автомашин жлоодох эрх бүхий даатгуулагч болон зөвшөөрөгдсөн этгээд жлоодож явсан үеийг;
- 2.1.16 “Зам тээврийн осол” гэдэгт тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцож байх үедээ зам тээврийн ослыг ойлгоно. Батлагдаагүй, зориулалтын буюу баталгаат бус замаар явсанаас үүдсэн болон автомашинныхаа хүч, туулах чадварыг үзэх, гол ус гатлах зэргээр автомашиндаа учруулсан хохирол хамаарахгүй;
- 2.1.17 “Баталгаат бус зам” гэдэгт газар товчлон гаралгүй газраар гол гатлах, гол, нуурын хөлдсөн мөсөн дээгүүр явах, жалга, гуу гатлах зэрэг үеийг ойлгоно. Үүнд: Өвөлжөө, хаваржaa руу явах үеийн зурvas замыг авч үзэхгүй.
- 2.1.18 “бүрэн сүйрэл” гэдэгт тээврийн хэрэгсэл, нөхөн сэргээгдэх, засварлагдах боломжгүй буюу нөхөн сэргээгдэх зардал нь даатгалын үнэлгээнээс хэтэрсэн байх нөхцөл байдлыг;
- 2.1.19 “суудлын гэнэтийн осол, эмчилгээний зардал” гэдэгт гэрээнд заасан эрсдлийн улмаас тухайн тээврийн хэрэгсэл дотор зорчин явсан зорчигчийн амь нас, эрүүл мэндэд гэмтэл хохирол учирсан тохиолдолд олгох нөхөн төлбөрийг;

### ГУРАВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

- 3.1 Дор дурдсан тээврийн хэрэгслийг даатгалын зүйлд тооцно. Үүнд:
- 3.1.1 Иргэн, хуулийн этгээдийн М, В, С, Д ангиллын тээврийн хэрэгсэл.
- 3.1.2 Даатгуулагчийн гаргасан хүсэлтийн дагуу хоёр тал харилцан тохиролцож тээврийн хэрэгсэлд анх үйлдвэрээс суурилуулсан иж бүрдэлд ороогүй, шинээр суурилуулсан аудио болон видео, гэрлэн болон дохиоллын, автомашин халаагч, байрлал тогтоогч болон бусад тоног төхөөрөмжийг нэмэлтээр даатгуулсан бол тэдгээр нь даатгалын зүйл болно.
- 3.1.3 Даатгагдсан зүйлийн өмчлөгч, эзэмшигчид өөрчлөгдсөн тохиолдолд даатгуулагч байгууллагын албан бичиг, шийдвэрийг үндэслэн хасалт хийх ба шинээр нэмж оруулах тээврийн хэрэгслүүдийг тоо болон үнийн дунд дүүцүүлэн нэмэлтээр даатгалд хамруулна.

### ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

- 4.1 Даатгуулагч даатгагчтай харилцан тохиролцож тээврийн хэрэгслээ дараах төрлөөс сонгон даатгуулах бөгөөд багцын сонголт нь баталгаанд заавал тусгагдсан байна.

1. Төгөлдөр даатгал

4.2	Даатгалын Эрсдэл	Хамгаалалтын хувь
4.2.1	Байгалийн хүчний үйлчлэлийн бүхийл эрсдэл	100
4.2.2	Хөдөлгөөний үеийн бүхий л осол, гэмтэл	100
4.2.3	Хөдөлгөөний бус үеийн бүхий л осол, гэмтэл	100
4.2.4	Сантехникийн эрсдэл	100
4.2.5	Төрлийн гал, тэсрэлт, дэлбэрэлт, шаталт	100
4.2.6	Хулгай, дээрэм	100
4.2.7	Бүхэлд нь хулгайд алдах эрсдэл	100
4.2.8	Жолоочийн гэнэтийн осол /5 сая төгрөг/	100
Нэмэлт үйлчилгээ		
4.3.1	24 цагийн ослын дуудлага	+
4.3.2	Даатгал, нөхөн төлбөрийн зөвлөгөө	+

4.3.3	Хохирлын үнэлгээний зардал	+
4.3.4	Ослын газраас тээвэрлэх зардал	+

### ТАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

- 5.1 Тээврийн хэрэгслийн даатгалын үнэлгээг зах зээлийн үнийн жишгийг харгалзан даатгагч, даатгуулагчтай харилцан тохиролцож тогтооно.
- 5.2 Даатгалын зүйлийн даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан тээврийн хэрэгслийн ортгөөс илүү байвал тухайн ортгөөс илүү гарсан хэсэгт нь гэрээ хүчин төгөлдөр бус байна.
- 5.3 Даатгалын зүйлийн даатгалын үнэлгээний хэмжээ нь түүний зах зээлийн бодит үнээс бага байвал нөхөн төлбөрийг даатгалын үнэлгээний зах зээлийн үнэд эзлэх хувиар хувь тэнцүүлэн олгоно.
- 5.4 Даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан зүйлийн ортоос үлмж их болон нь тогтоогдвол даатгагч даатгалын үнэлгээний хэмжээг бууруулах, даатгуулагч хураамжийг багасгахыг тус тус шаардах эрхтэй.
- 5.5 Даатгуулагч даатгалын үнэлгээний хэмжээг зориуд өсгөсөн бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох бөгөөд энэ байдлыг даатгагч гэрээ байгуулах үедээ мэдээгүй байсан бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцохоос өмнө даатгуулагчийн төлсөн хураамж даатгагчид үлдэнэ.
- 5.6 Даатгалын зүйлийн даатгалын үнэлгээг даатгуулагчтай харилцан тохиролцсоноор үйлдвэрлэгдсэн он, Монгол улсад орж ирсэн он, ашиглагдсан хугацаатай уялдуулан элэгдлийг хасан үнэлгээ хийсэн бол энэ талаар даатгалын гэрээнд заавал тусгана.
- 5.7 Даатгуулагчийн төлөх даатгалын хураамжийн хувь хэмжээ нь тээврийн хэрэгслийн төрөл ангилаал, үнэлгээ, ашиглалт зэрэг эрсдэлд нөлөөлөх хүчин зүйл, даатгуулагчийн сонгосон бүтээгдэхүүний төрөл, нэмэлт эрсдэлээс хамаарах бөгөөд даатгалын мэргэжилтэн тооцож тогтоож болно.
- 5.8 Даатгалын хугацаанд даатгуулагч нөхөн төлбөр аваагүй тохиолдолд даатгагч хохиролгүйн хөнгөлөлт үзүүлж болно.
- 5.9 Даатгалын үнэлгээ, хураамжийн хэмжээ, хураамж төлөх хугацааг даатгалын гэрээнд тодорхой заана.
- 5.10 Хураамж төлөх хугацааг гэрээнд тодорхой заасан байна. Гэрээнд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, заасан хугацаанд хураамж төлөгдсөнөөр даатгалын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 5.11 Даатгуулагч байгууллагын тээврийн хэрэгсэл ашиглалтаас хасагдах, шинээр нэмэгдэх, тухайн байгууллага татан буугдах зэрэг өөрчлөлт хөдөлгөөн орсон тохиолдолд даатгуулагч нь тухай бүр даатгалын хураамжийг буцаалт хэлбэрээр авч, эсвэл нэмж даатгуулах боломжтой.
- 5.12 Даатгалын хураамжийг 2022 он ...-р сарын ...-ны өдрийн дотор “МИГ Даатгал” ХХК-ийн **Худалдаа хөгжлийн банкны 431012030 тоот дансанд шилжүүлнэ.**
- 5.13 Даатгалын хугацаанд даатгуулагч энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөр олгосон тохиолдолд даатгалын үнэлгээ гэрээний үлдэх хугацаанд нөхөн төлбөр олгосон хэмжээгээр буурах бөгөөд зохих хураамжийг төлсний үндсэн дээр даатгалын үнэлгээг дахин сэргээж болно.

### ЗУРГАА. ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ХУГАЦАА, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ.

- 6.1 Даатгалын гэрээ байгуулахдаа тусгайлан заагаагүй бол гэрээг 1 жилээр байгуулна.
- 6.2 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно.
  - 6.2.1 Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
  - 6.2.2 Даатгагч, даатгуулагчийн аль нэг дампуурсан, татан буугдсан;
  - 6.2.3 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
  - 6.2.4 Даатгалын зүйл шүүхийн шийдвэрээр хураагдсан;
  - 6.2.5 Гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгохоор талууд тохиролцсон;

- 6.2.6 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- 6.2.7 Даатгалын зүйл даатгалын тохиолдлоос бусад тохиолдлоор устаж үгүй болсон;
- 6.2.8 Хоёр талын аль нэг нь гэрээг цуцлах тухай санаачлага гаргаж болох бөгөөд нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор гэрээг цуцална.
- 6.2.9 Даатгуулагч даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдлын тухай бичгээр мэдээлэх үүргээ санаатайгаар биелүүлээгүй бол даатгагч өөрийн санаачлагаар гэрээг цуцалж болно.

## **ДОЛОО. ДААТГУУЛАГЧ, ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **7.1 Даатгуулагчийн эрх, үүрэг:**

- 7.1.1 Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг гэрээнд заасны дагуу даатгагчаас гаргуулан авах эрхтэй.
- 7.1.2 Даатгалын хууль, журам, гэрээтэй холбоотой тайлбар, зөвлөгөө авах эрхтэй.
- 7.1.3 Даатгалын гэрээг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж авах эрхтэй.
- 7.1.4 Даатгагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй.
- 7.1.5 Даатгалын зүйлийн үнэлгээ тогтооход даатгуулагчтай тохиролцох эрхтэй.
- 7.1.6 Даатгуулагч даатгалын зүйлийн улсын дугаар, хөдөлгүүрийн дугаар өөрчлөгдөх, өнгө солигдох зэргээр өөрчлөлт орсон тохиолдолд даатгагчид нэн даруй мэдэгдэн даатгалын гэрээндээ өөрчлөлт оруулах үүрэгтэй.
- 7.1.7 Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орж, шинэ өмчлөгчид шилжүүлсэн тохиолдолд даатгуулагч эсвэл шинэ өмчлөгч даатгагчид нэн даруй мэдэгдэн даатгалын гэрээгээ цуцлах, шинээр байгуулах асуудлаар санаалаа ирүүлэх үүрэгтэй.
- 7.1.8 Даатгалын зүйлд нэмэлтээр байрлуулсан тоног төхөөрөмжийн талаар даатгалын гэрээ байгуулах үедээ даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.
- 7.1.9 Даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид төлөх үүрэгтэй.
- 7.1.10 Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдлын үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой бүхий л арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 7.1.11 Даатгалын тохиолдлын талаар даатгагчид Шуурхай албаны 24 цагийн үйлчилгээтэй 7575-6000 утсаар, email: claims@mig.mn нэн даруй мэдэгдэж хүндэтгэх шалтгаангүй бол даатгалын ажилтан, замын цагдаа ирж үзтэл тээврийн хэрэгслийг ослын дараах байдлаар нь хадгалж ослын шалтгааныг тогтоолгох үүрэгтэй.
- 7.1.12 Даатгалын гэрээ байгуулах үеийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлүүд өөрчлөгдсөн тохиолдолд даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.
- 7.1.13 Даатгалын хууль, гэрээний дагуу даатгагчаас гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авахад даатгагчид бүх талын туслалцааг үзүүлэх үүрэгтэй.
- 7.1.14 Хохирлын талаар даатгагчид үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.
- 7.1.15 Даатгалын тохиолдлын үед даатгалын гэрээ болон баталгаанд заасан өөрийн хүлээх хариуцлагын хэмжээгээр үүрэг хүлээх.
- 7.1.16 Даатгал хийлгэхтэй болон нөхөн төлбөр гаргуулан авахтай холбоотой баримт, материалыг даатгагчид саадгүй, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй;
- 7.1.17 Монгол улсын замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм журмыг ёсчлон биелүүлж хөдөлгөөнд оролцох үүрэгтэй.
- 7.1.18 Тээврийн хэрэгслийн найдвартай байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчээс гаргасан ашиглалтын горим, зааврыг зөрчилгүй, даац, ачаалал хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.

### **7.2 Даатгагчийн эрх, үүрэг:**

- 7.2.1 Даатгалын тохиолдол бий болж, даатгагчийн төлбөл зохих нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа даатгагч үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.
- 7.2.2 Даатгалын тохиолдол бий болсон үед нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай аливаа мэдээг даатгуулагчаас шаардах эрхтэй.
- 7.2.3 Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй.
- 7.2.4 Даатгуулагч хуурамч мэдээлэл өгсөн нь нотлогдвол түүнчлэн даатгалын хураамжийг хууль буюу гэрээгээр тогтоосон хугацаанд төлөөгүй бол гэрээг цуцлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй.
- 7.2.5 Даатгалын тохиолдлын газар дээр очиж даатгалын гэрээнд заасан эрсдэл үүссэн эсэхийг нягталж тогтоох, учирсан хохирлын хэмжээг нэг бүрчлэн тогтоож даатгуулагчид танилцуулах үүрэгтэй.
- 7.2.6 Даатгуулагчид учирсан хохиролд зах зээлийн үнийн судалгаа хийсний үндсэн дээр үнэлгээ хийж даатгуулагчид танилцуулах үүрэгтэй.
- 7.2.7 Даатгуулагчаас ирүүлсэн нөхөн төлбөрийн материалыг хүлээн авч шаардлагатай гэж үзвэл нэмэлт материал гаргуулан авах эрхтэй.
- 7.2.8 Даатгуулагчийн ирүүлсэн даатгалын нөхөн төлбөр хүссэн баримт материал эргэлзээтэй тохиолдолд эрх бүхий байгууллага албан тушаалтанд хандаж дүгнэлт тодорхойлолт гаргуулах.
- 7.2.9 Даатгалын зүйлийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж шалгах эрхтэй.
- 7.2.10 Шаардлагатай тохиолдолд жолоо барьж явсан хүнийг согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, шалгуулах эрхтэй.
- 7.2.11 Даатгалын тохиолдлын улмаас бүрэн сүйрсэн тээврийн хэрэгсэл болон гэмтсэн эд ангийг даатгагч шинээр сольж, нөхөн сэргээсэн бол тухайн тээврийн хэрэгсэл, гэмтсэн эд ангийг өөрийн мэдэлд авах эрхтэй.
- 7.2.12 Даатгалын гэрээний 8.10-8.11-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд заасан хугацаанд нөхөн төлбөр олгоогүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хүртэлх хувиар алданга тооцно.
- 7.2.13 Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд даатгуулагчийн талаар өөрт хадгалагдаж буй мэдээ материалын нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.
- 7.2.14 Даатгалын гэрээ байгуулах, үүссэн хохирлыг шуурхай барагдуулах үүднээс даатгуулагчид хууль тогтоомж, гэрээний нөхцөлийн талаар үнэн зөв мэдээлэл, бүрдүүлэх баримтын асуудлаар зөвлөгөө өгөх үүрэгтэй.
- 7.2.15 Даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний зардлыг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж тооцох (нийлбэр нөхөн төлбөрийн хэмжээ даатгалын үнэлгээнээс ихгүй байна.)

## **НАЙМ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ, ТООЦОХ НӨХЦӨЛ**

- 8.1 Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон тэдгээрт нийцуулэн гаргасан журам, заавар, даатгалын гэрээгээр зохицуулагдана.
- 8.2 Даатгагч нь даатгалын тохиолдол болсон үед дор дурьдсан баримт материалыг үндэслэн даатгалын гэрээ болон баталгаанд заасны дагуу нөхөн төлбөр олгоно.
  - 8.2.1 Даатгуулагчийн даатгалын нөхөн төлбөр хүссэн өргөдөл, албан бичиг.
  - 8.2.2 Даатгалын гэрээ, баталгааны эх хувь.
  - 8.2.3 Даатгалын тохиолдлын газар дээр ажилласан тухай Шуурхай Албаны протокол, дүгнэлт.
  - 8.2.4 Даатгуулагч буруутай эсэхийг магадлах зорилгоор ослын шалтгааныг тогтоосон зам тээврийн ослын акт, тодорхойлолт.

- 8.2.5 Учирсан хохиролд үнэлгээ хийсэн эрх бүхий байгууллагын үнэлгээний тайлан.
- 8.2.6 Эвдрэл гэмтэлд засвар хийсэн бол засварын газрын баримт.
- 8.2.7 Зам тээврийн осол болон эвдрэл, гэмтлийн байдлыг харуулсан фото зураг.
- 8.2.8 Шаардлагатай тохиолдолд гал, үнэлгээ зэрэг мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагын дүгнэлт, тодорхойлолт.
- 8.2.9 Зам тээврийн ослын хэрэг нь Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллагад шалгагдаж, хянаадж байгаа тохиолдолд тэдгээр байгууллагын шийдвэр.
- 8.3 Даатгалын зүйлд учирсан эвдрэл гэмтлийн хохиролд нөхөн сэргээх үнэлгээнээс түүний элэгдлийг тооцон, гэрээнд заасан даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг хасч тооцон нөхөн төлбөр олгоно.
- 8.4 Хохирол нь даатгуулагчийн буруутай (энэхүү гэрээний 8.5.1 болон 8.5.2 -д зааснаас бусад) үйлдлээс шалтгаалсан бол даатгуулагчийн сонгосон даатгалын багцаас хамааран эрсдэл хэсэгт зааснаас өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг хассан дунгээр нөхөн төлбөр олгоно.
- 8.5 Даатгуулагчийн дараах буруутай үйлдлээр тээврийн хэрэгсэлд учирсан хохиролд дор дурьдсан хувь хэмжээгээр нөхөн төлбөр олгоно. Үүнд:
  - 8.5.1 Урсгал сөрсөн, гүйцэж түрүүлсэн, эргэх үйлдэл хийхийг хориглосон газар эргэсэн, гүйцэж түрүүлсэн, зөвшөөрөгдөгүй гэрлэн дохиогоор хөдөлгөөн хийсэн, ослын дохио болон зогсолтын тэмдэг хэрэглээгүй, түр зогсохыг хориглосон газар зогссон, зам тээврийн ослын талаар замын цагдаа болон даатгагчид нэн даруй мэдэгдэх даатгуулагчийн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдуудад нөхөн төлбөрийг гарсан хохирлын дунгийн 60 хувиар олгоно.
  - 8.5.2 Хурд хэтрүүлсэн нь мэргэжлийн эрх бүхий байгууллага болон экспертийн дүгнэлтээр тогтоогдсон, мал, амьтан мөргөсөн зэрэг тохиолдуудад гарсан хохирлын дунгийн 40 хувиар олгоно;
- 8.6 Тээврийн хэрэгслийн шилний хохирол нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхгүй тохиолдолд засварын зардлын хэмжээгээр нөхөн төлбөр олгох ба хэрвээ уг хохирол нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхөөр болсон тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг шил шинээр тавьсан зардлын хэмжээгээр тооцно.
- 8.7 Хэрэв даатгуулын зүйлд гуравдагч этгээд хохирол учруулсан ба гарсан хохирлыг буруутай этгээдийн жолоочийн хариуцлагын даатгалаар барагдуулж болохуйц тохиолдолд даатгагч нь даатгуулагчийнхаа эрхийг хамгаалах үүднээс нөхөн төлбөрийг энэ гэрээний журмын дагуу даатгуулагчид олгож, олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс (түүний даатгуулсан компанийс) нэхэмжилнэ.
- 8.8 Даатгалын хугацаанд олгогдох нөхөн төлбөрийн нийт хэмжээ баталгаанд заасан даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.
- 8.9 Нөхөн төлбөрийг мөнгөн хэлбэрээр төлөх эсвэл сэлбэх, засварлах, солих зэргийг Даатгуулагчийн саналыг авч даатгагч өөрийн сонголтоор шийдвэрлэнэ.
- 8.10 Тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийг даатгагч нөхөн төлбөр хүссэн өргөдөл, материалыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан олгоно.
- 8.11 Даатгуулагчаас хүлээн авсан өргөдөл материал нь гэрээнд заасан нотлох баримтын шаардлага хангахгүй дутуу, эргэлзээтэй байх эсвэл тухайн асуудлаар эрх бүхий байгууллагаар дүгнэлт тодорхойлолт гаргуулахаар даатгагч хүсэлт гаргасан, эсвэл эрх бүхий байгууллага хянаж шалгаж шийдвэр гаргаагүй байгаа тохиолдолд энэ нөхцөлийн 8.10-д заасан хугацаа үйлчлэхгүй.
- 8.12 Гэнэтийн осол, эмчилгээний зардал нь тухайн тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндэд ослын улмаас учирсан бэртэл гэмтлийг эмчлэх эмчилгээний зардлын баримтыг үндэслэн олгогдоно.
- 8.13 Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.7, Иргэний хуулийн 443.7 дахь заалтыг үндэслэн Даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдои гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

- 8.14 Даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн тохиолдолд Даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг үл маргах журмаар даатгагчид шилжүүлнэ.
- 8.15 Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах даатгагчийн эрхийг даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд даатгагч даатгуулагчид олгосон нөхөн төлбөрийг тэр хэмжээгээр буцаан нэхэмжлэнэ.
- 8.16 Байгалийн гамшиг, гал, усны аюулаас хүний амь, эрүүл мэнд хохирсон, хөрөнгөд онц их хэмжээний хохирол гарсан даатгалын тохиолдолын үед талууд зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран хохирлын шалтгаан, хэмжээг тогтоох комисс томилон ажиллах ба комиссын бүрэлдэхүүнд даатгагч, даатгуулагчийн төлөөлөгч байхаас гадна шаардлагатай бол хууль хяналт, гал, ус цаг уурын албаны төлөөлөгч зэрэг холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.
- 8.17 Томилогдсон комисс даатгалын тохиолдлын шалтгаан, хохирлын хэмжээг газар дээр нь шалган шинжлэн судалж, хохирлын шалтгааныг тогтоосон актыг үйлдэнэ.
- 8.18 Даатгуулагч нь даатгалын зүйлийг хэд хэдэн компанид зэрэг даатгуулсан болон энэхүү даатгалын гэрээгээр олгогдох нөхөн төлбөр нь өөр даатгалын гэрээгээр мөн нөхөн төлөгдөхөөр байвал Даатгагч нь учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр хариуцахгүй бөгөөд бусад даатгалын компанийтай тохиролцож хохирлын хэмжээнээс ихгүй байхаар тооцож нөхөн төлбөрийг олгоно.

#### **ЕС. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛ /ХАСАЛТ/**

- 9.1 Даатгагч нь нөхөн төлбөрөөс татгалзах үндэслэлээ тодорхой гаргаж даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.
- 9.2 Даатгагч нь Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл үүсвэл нөхөн төлбөр олгохоос татгалзах эрхтэй бөгөөд энэхүү даатгалын онцлогоос шалтгаалан дор дурьдагдсан тохиолдлуудад даатгагч нөхөн төлбөрийн хариуцлага хүлээхгүй. Үүнд:
  - 9.2.1 Даатгуулагч буюу түүний ашиг сонирхлыг хамгаалагч этгээд санаатайгаар хохирол учруулсан болон хохирол гарах орчин, нөхцөлийг бүрдүүлсэн;
  - 9.2.2 Даатгалын гэрээнд тусгагдаагүй эрсдэлийн улмаас гарсан хохирол;
  - 9.2.3 Даатгуулагч даатгалын зүйл болон нөхөн төлбөрийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
  - 9.2.4 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн.
  - 9.2.5 Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл үүссэн.
- 9.3 Даатгалын гэрээ байгуулсан боловч даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй байхад даатгалын тохиолдол үүссэн бол;
- 9.4 Тээврийн хэрэгслийн дугуй, явах эд ангийн ердийн элэгдэл, гэмтэл, үйлдвэрийн гологдол, тэнхлэг тохиргоо алдагдах зэргээс учирсан эвдрэл, хохирол, байршил тогтоогч, халаагч зэрэг нэмэлт тоног төхөөрөмжийг буруу суурилуулснаас үүссэн хохирол, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрт хийсэн ээлж, гагнуур зэрэг засварын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан хохирол.
- 9.5 Даатгал хийхийн өмнө оршиж байсан дутагдал, согогийн улмаас гарсан эвдрэл гэмтэл нь даатгал хийх үед тухайн тээврийн хэрэгсэлд хийсэн үзлэг, фото зургаар баталгаажсан эсвэл Шуурхай Алба, Замын цагдаагийн ослын газарт хийсэн акт дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд.
- 9.6 Даатгуулагч тээврийн хэрэгслээ ашиглан гэмт хэрэг үйлдсэн, жолоодох эрхгүй хүнд жолоо шилжүүлсэн, тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эрүүл мэндийн хувьд жолоо барих шаардлага хангахгүй этгээдээр жолоо бариулсан нь эрх бүхий байгууллагын акт дүгнэлтээр тогтоогдсон үед учирсан хохирол;
- 9.7 Тээврийн хэрэгслийг согтуугаар болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоодсоноос үүдэн гарсан хохирол;

- 9.8 Тээврийн хэрэгслийг ашиглахыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хориглосон шийдвэр гаргасан үед тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оруулснаас үүссэн хохирол;
- 9.9 Тээврийн хэрэгслийг жолооны сургалтын зориулалтаар ашиглах, ан ав хөөх, уралдаан тэмцээнд оролцуулах, тээврийн хэрэгслийн хүч, туулах чадварыг турших, баталгаат бус замаар зорчин хад чулуу мөргөх, гол ус гатлах зэргээс учирсан хохирол;
- 9.10 Зорчиг болон ачаа тээш тээвэрлэх журмыг зөрчсөнөөс үүссэн хохирол;
- 9.11 Хохирлын шалтгаан тодорхой бус, нөхөн төлбөрийг шийдвэрлэх үед хохирлын шалтгааныг тогтоох боломжгүй болсон хохирол;
- 9.12 Гэрээнд тусгайлан заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэрээс гаднах хохирол;

**АРАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, НУУЦЛАЛ**

- 10.1 Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, ноу-хау зэргийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүйгээр хугацаагүй чанд хадгална.
- 10.2 Талууд даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд гэрээний үлдсэн хугацаанд ногдох хураамжаас тухайн даатгалтай холбогдсон зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно. Нөхөн төлбөр авсан болон 9 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд буцаалт хийхгүй.
- 10.3 Даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөр авах зорилгоор нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн бол даатгагчаас гэрээг цуцалж, хариуцлага хүлээлгэхээр баримтыг хуулийн байгууллагад шилжүүлнэ.

**АРВАН НЭГ. БУСАД**

- 11.1 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт өөрчлөлтийг энэхүү гэрээнд зөвхөн бичгээр оруулж гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцно.
- 11.2 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд талууд энэхүү нөхцлөөр цаашид үргэлжлүүлэн сунгах талаар хэлэлцэн тохиролцож гэрээний хугацааг шинэчлэн тогтоож баталгаажуулснаар даатгалын гэрээ сунгагдана.
- 11.3 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжинд заагсдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Энэхүү гэрээг Монгол хэлээр хууль зүйн хувьд адил хүчинтэй 2 эх хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгалав.
- 11.4 Хэрэв тухайн даатгалын гэрээ нь Монгол болон гадаад хэл дээр давхар үйлдэгдсэн бол Монгол гэрээ нь давуу эрхтэй болно.
- 11.5 Энэхүү гэрээ түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар талуудын хооронд маргаантай асуудал үүсвэл, юуны өмнө эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв ийнхүү шийдвэрлэж чадахгүйд хүрвэл талууд Санхүүгийн Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвэл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.
- 11.6 Даатгагч нь даатгуулагчид тээврийн хэрэгсэл даатгагдсан тухай нотолгоо болгож даатгалын баталгаа олгосон бөгөөд энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.



## НӨХӨН ТӨЛБӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБОГДОХ УТАС, ХАЯГ:

**Хаяг:** МОНГОЛ УЛС, Улаанбаатар 15170, Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 5/1,  
МИГ Даатгал компаний байр

**24 Цагийн шуурхай албаны утас:** (+976)-7575-6000

**Төв компаний утас:** (+976)-7575-6000 /Мэдээлэл, асуулт хариулт, зөвлөгөө/  
**Э-Шуудан:** [claim@mig.mn](mailto:claim@mig.mn)

# МС ДААТГАЛ

Даатгагч: “МИГ Даатгаал” ХХК  
Даатгууллагч: Иргэний нисэхийн өрөнхий газар

22201/1257 тоот гэрээний хавсралт №1

№/д	Тээврийн хэрэгслийн марк	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Үлсын дугаар	Даатгалын үнэлгээ	Даатгалын хураамжийн хувь	Даатгалын хураамж /нөгрөг/
1	Toyota Landcruiser-200	JTMHU091604082845	2013	0089 УБН	117,981,000	0.43%	507,318.30
2		KMHL3416BLA039751	2019	7592 УНВ	89,600,000	0.43%	385,280.00
3	Hyundai SonataDN8	KMHL3416BLA039747	2019	0232УНУ	89,600,000	0.43%	385,280.00
4		KMHL3416BLA039749	2019	0283 УБУ	89,600,000	0.43%	385,280.00
5	Kia Optima	KNAGT411BG5104037	2016	1986 УНИ	54,000,000	0.43%	232,200.00
6	Hyundai Sonata-NF	KMHET41CP7A390824	2007	8970 УБВ	26,003,802	0.43%	111,816.35
7		KMHEB41AAEA610359	2013	3834 УБҮ	55,000,000	0.43%	236,500.00
8	Hyundai Sonata-YF	KMHEB41BBBA255380	2011	3002 УНН	34,285,000	0.43%	147,425.50
9		KMHEB41BAB299027	2011	9917 УНУ	33,456,517	0.43%	143,863.02
10		KMHE241CBGA238083	2016	5700 УНМ	64,000,000	0.43%	275,200.00
11	Hyundai Sonata -LF	KMHET41BP5A031483	2006	3430 УБИ	26,903,445	0.43%	115,684.81
12		KMHE241CBGA238082	2016	1130 УНС	64,000,000	0.43%	275,200.00
13		1N4AL3AP8GC187608	2016.12	0246 УБИ	70,270,573	0.43%	302,163.46
14	Nissan Teana	1N4AL3AP3GC184776	2016.12	0113УБИ	61,397,500	0.43%	264,009.25
15		JN1VB4E26Z0000140	2016.12	0371 УБИ	59,900,000	0.43%	257,570.00
16		JN1VB4E26Z0015003	2019.09.17	5753 УНЦ	77,000,000	0.43%	331,100.00
17	Nissan Urvan	JN1VB4E26Z0015066	2019.11.12	3616 УБЕ	77,000,000	0.43%	331,100.00
18		JN1VB4E26Z0015068	2019	9154 УНЭ	77,000,000	0.43%	331,100.00
19		JN1VB4E26Z0015065	2019	2835УНЗ	77,000,000	0.43%	331,100.00
20		JN1VB4E26Z0015070	2019	9187 УНУ	77,000,000	0.43%	331,100.00
21		220695G04939932	2016.12	0471 УБИ	26,850,000	0.43%	115,455.00
22	Уаз-220695	XTT220695K1211464	2019	9875 УНЭ	31,500,000	0.43%	135,450.00
23		220695G0495380	2016.12	0411 УБИ	26,850,000	0.43%	115,455.00
24		220695G0494192	2016.12	0184 УБИ	26,850,000	0.43%	115,455.00

# МС ДААТГАЛ

25		220695G0493987	2016.12	0482 УБИ	26,850,000	0.43%	115,455.00
26		220695G0494082	2016.12	0398 УБИ	26,850,000	0.43%	115,455.00
27		220695G0481547	2016	5489 УБК	25,850,000	0.43%	111,155.00
28	Yaz-2206	374100D0412355	2013	8247 УНД	27,000,000	0.43%	116,100.00
29	Hyundai Starex	KMJWA37JBAU229644	2010	2819 УНЦ	36,800,000	0.43%	158,240.00
30		KMJWA37JBAU221873	2011	7862 УНР	34,333,334	0.43%	147,633.34
31		KMJWA37RAGU780715	2015.09	1315 УБК	59,800,000	0.43%	257,140.00
32		KMJWA37JBBU173465	2011	7863 УНР	34,333,333	0.43%	147,633.33
33		KMJWA37RADU583847	2013	6153 УНВ	43,350,000	0.43%	186,405.00
34		KMJWA37RADU583588	2013	5791 УНВ	43,350,000	0.43%	186,405.00
35	Hyundai Starex	KMJWA37RACU583349	2013	4732 УНВ	43,350,000	0.43%	186,405.00
36		KMJWA37RACU415986	2011	3061 УНУ	37,000,000	0.43%	159,100.00
37		KMJWA37RACU416375	2011	3062 УНУ	34,400,000	0.43%	147,920.00
38		KMJWA37RACU432879	2011	3063 УНУ	34,400,000	0.43%	147,920.00
39		KMJWA37RAKU071612	2019	0184 УНИ	86,500,000	0.43%	371,950.00
40		KMJWA37RADU534290	2012	4890 УНЛ	38,000,000	0.43%	163,400.00
41		KMJWA37RAGU780504	2015.09	1585 УБК	59,800,000	0.43%	257,140.00
42		KMJHD17LBPC048983	2010	5285 УНП	65,265,000	0.43%	280,639.50
43		KMJHG17FPFC066379	2015	6102 УБЕ	110,000,000	0.43%	473,000.00
44	Hyundai County	KMJHG17FPBC052009	2011	0963 УНЭ	69,500,000	0.43%	298,850.00
45		KMJHG17FPHC0711871	2016	7315 УНС	130,000,000	0.43%	559,000.00
46		KMJHG17B5GC070785	2016.08	5371 УНЦ	130,000,000	0.43%	559,000.00
47		KMJHG17B3G070784	2016.08	6643 УНЦ	130,000,000	0.43%	559,000.00
48	Daewoo BS-106	LGLFD5AXEK200573	2014	7972 УНУ	191,500,000	0.43%	823,450.00
49		KL5UM52JEBU006346	2011	4174УНЭ	130,000,000	0.43%	559,000.00
50		LGLFD5AXEK200574	2014	7970 УНУ	191,500,000	0.43%	823,450.00
51		KMJRG18TPHC914718	2016	4034 УНЗ	270,752,500	0.43%	1,164,235.75
52		KMJKG18TPHC914701	2016	4109 УНЗ	270,752,500	0.43%	1,164,235.75
53	Hyundai UniverseSpace	KMJKG18TPHC914713	2016	4011УНЗ	270,752,500	0.43%	1,164,235.75
54		KMJKG18TPHC914706	2016	4042 УНЗ	270,752,500	0.43%	1,164,235.75
55		KMJKG18TPHC914732	2016	4158 УНЗ	270,752,500	0.43%	1,164,235.75
56		KMJKG18TPHC914705	2016	4129 УНЗ	270,752,500	0.43%	1,164,235.75

# МС ДАТГАЛ

57	Kia K 2700 Bongo	KNC SHY71CK7366419 KNC SHY71CK7366420	2019	8757 УНО	64,400,000	0.43%	276,920.00
58	Ford ranger	MNCLMFF50FW434104	2015	8573 УБП	65,000,000	0.43%	279,500.00
59	Nissan Navara	MNTCC4D23Z0018037	2016.12	0284 УБИ	68,900,000	0.43%	296,270.00
60	Toyota Landcruiser-79	JTEBB71J904320845	2016.11	5591 УБУ	156,590,000	0.43%	673,337.00
61	Hyundai HD-120	KMF LA18KPMC132750	2020.12	5370 УАР	270,900,000	0.43%	1,164,870.00
62	Зил-45085	3478947	2004	7813 УБИ	28,000,000	0.43%	120,400.00
63	Howo	LZZ5ELSD2GN027958	2019	1662 УБК	124,000,000	0.43%	533,200.00
64		KMF DA18CPDC075493	2013	4779 УНВ	179,260,620	0.43%	770,820.67
65	Hyundai HD-250	KMF DA18CPKC1011882	2018	4761 УНД	349,900,000	0.43%	1,504,570.00
66		KMF DA18CPCC094208	2016	4795 УНЧ	294,000,000	0.43%	1,264,200.00
67	АЦ-5.5-375	406291	1983	3203 УБХ	9,333,500	0.43%	40,134.05
68	T3A 7.5-5334	47094	1999	0963 УБИ	50,250,000	0.43%	216,075.00
69	Dongfeng.SCS5256GYYEQ	LGHXH4XLB320591 LGHXH4XL320592	2020.12	5340 УАР	281,272,727	0.43%	1,209,472.73
70	Nissan Patrol	JN1TANY62Z0100035	2017	5380 УАР	281,272,727	0.43%	1,209,472.73
71	Staria	KMJYD374BNU059305	2022.5	0232 УНУ	198,000,000	0.43%	851,400.00
72	Staria	KMJYD374BNU058969	2022.5	0912 УБ3	113,090,909	0.43%	486,290.91
73				0914 УБ3	113,090,909	0.43%	486,290.91
74							
<b>БҮЯНТ-УХАА ОУНБ-Д</b>							
1	Ko-829A1 /Камаз 43253/	XTC432533C1267040 XTC432533B1225872	2013	7047 УНО	137,300,000	0.43%	590,390.00
2	J208	J208	2011	2940 УНУ	139,864,527	0.43%	601,417.47
3	Д3-224A	204	1988	2674 УБХ	18,741,900	0.43%	80,590.17
4	SAAB-9.5	4EX309034	1999	9864 УБР	16,907,429	0.43%	72,701.94
5	SDLG953	VLG00953LJ0003524	2018	4475 УБЭ	187,514,000	0.43%	806,310.20
6	World W136	VLG00953LJ0003525	2018	3216 УБ	178,500,000	0.43%	767,550.00
7	TMX - 400	53D203	1999	0567 УН	178,500,000	0.43%	767,550.00
8				5165 УН	304,120,300	0.43%	1,307,717.29
9	JST-25	T25847	2011	5093 УБ	68,000,000	0.43%	292,400.00
10	ОшкотГ-1500	VS063535	1997	1401 УББ	621,141,400	0.43%	2,670,908.02
11		VS063565	1997	1501 УББ	621,141,400	0.43%	2,670,908.02
12	Камаз-43118	XTC43118KA2373566	2010	7095 УНЦ	175,000,000	0.43%	752,500.00

# М/С ДААТГАЛ

13	Hyundai Starex GRX	KMHWP81JP5U639889	2007	0653УНП	31,895,000	0.43%	137,148.50
<b>ЧИНГИСХААН ОУНБ-Д</b>							
1	Ko-829A /Зип433362/	3478947	2004	8352ХОҮ	60,125,000	0.43%	258,537.50
2	TMX-400	53D202	1999	0131УБ	334,120,300	0.43%	1,436,717.29
3	APRON, KG-B6300	11320329	2011	4312УНЭ	190,000,000	0.43%	817,000.00
4	TECO-V5 50 IP	1GSM7H1C2XJ511018	1999	7334УБЭ	196,539,600	0.43%	845,120.28
5		946590	1994	9204 УБЯ	19,028,300	0.43%	81,821.69
6		2002945579	1994	9205 УБЯ	19,028,300	0.43%	81,821.69
7	УМП-350-131	2002946808	1994	9206 УБЯ	19,028,300	0.43%	81,821.69
8		878750	1990	9207 УБЯ	9,000,000	0.43%	38,700.00
9		14675	2007	7676УБ	39,905,334	0.43%	171,592.94
10	JST-25	T25846	2011.01	5091УБ	68,000,000	0.43%	292,400.00
11	QCD25-KM	10139	2010	5109УБ	72,680,000	0.43%	312,524.00
<b>ШИБШХА-ны автомашинууд</b>							
1	Tri-state R7000-j800	AR771	2000	1183УН	143,547,193	0.43%	617,252.93
2		AR770	2000	1184УН	135,552,357	0.43%	582,875.14
3		LWLDAAIG2GL059335	2016	4251УAB	816,060,000	0.43%	3,509,058.00
4		LWLDAAIG9GL059333	2016	4261УAB	816,060,000	0.43%	3,509,058.00
5	ISUZU QL1070	LWLDAAIG1GL058385	2016	4371УAB	816,060,000	0.43%	3,509,058.00
6		LWLDAAIG0GL059334	2016	4391УAB	816,060,000	0.43%	3,509,058.00
					14,858,376,538		63,891,9,19.11
<b>Нийт 104 тээврийн хэрэгсэл</b>							

Гэрээний эхлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс  
Дуусах хугацаа 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 24:00 цаг хүртэл

Даатгагчийг төлөөлж: МИГ ДААТГАЛ ХХК-Н ЕРОНХИЙ МЕНЕЖЕР  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН НЯГТЛАН БОДОГЧ  
Даатгагчийг төлөөлж: ИРГЭНИЙ НИСЭХИЙН УНДЭСНИЙ ТӨВИЙН  
Х.БОЛОР-ЭРДЭНЭ/

